МОНГОЛ УЛСЫН
ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН
БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИСС

Засгийн газрын II байр Нэгдсэн үндэстний гудамж 5/1 тоот
Чингэлтэй дүүрэг Улаанбаатар хот 15160
Утас: 265068, Факс: 320178
Вэб сайт: http://tsauzbuk.mn/

2023.05.24 № 143

танай ____________-ны № ____________-т

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА БӨГӨӨД ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ САЛБАР КОМИССЫН ДАРГА НАРТ

Хуулийн төсөлд санал
авах тухай

Улсын комиссоос боловсруулж буй Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэгт заасны дагуу олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах, мөн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт заасны дагуу салбар комиссын зүгээс санал авах шаардлага тус тус үүсээд байна.

Иймд хуулийн төсөлд санал авах олон нийтийн хэлэлцүүлгийг орон нутгийн түвшинд зохион байгуулж иргэдээс ирүүлсэн санал болон салбар комиссоос гаргасан саналыг хавсралтад заасан товьёгийн дагуу нэгтгэн 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн дотор Улсын комиссын ажлын албанд ирүүлнэ үү.

Жич: Саналын товьёг болон Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хавсаргав.

Хавсралт 38 хуудастай.

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Г.ТӨГӨЛДӨР

Улсын комиссын нарийн бичгийн даргын
2023 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн
143 дугаар албан бичгийн хавсралт

УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙГ ЦАГААТГАХ, ТЭДЭНД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ............................ АЙМАГ /ДҮҮРЭГ/ -ИЙН ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ САЛБАР КОМИССООС ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬЁГ

| № | Саналын агуулга | Санал ирүүлсэн албан тушаалтны нэр | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | | | |
| 2 | | | |
| ... | | | |

УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙГ ЦАГААТГАХ, ТЭДЭНД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ............................ АЙМАГ /ДҮҮРЭГ/ -ИЙН ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬЁГ

| № | Саналын агуулга | Санал ирүүлсэн хүний нэр | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | | | |
| 2 | | | |
| ... | | | |

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

# УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙГ ЦАГААТГАХ ТЭДЭНД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг:**

"6.3.Цагаатгуулах тухай гомдлыг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор гаргаж болох бөгөөд энэ хугацаанаас хойш гаргасан гомдлыг хүлээж авахгүй."

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

БАТЛАВ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА,
ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН
БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН ДАРГА
С.ОДОНТУЯА

# "УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙГ ЦАГААТГАХ, ТЭДЭНД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ" ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

## Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлаас 1998 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр "Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай" хуулийг батлан, хэрэгжүүлж эхэлснээс хойш 24 жил болж байна.

"Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай" хуулийг хэрэгжүүлж ажиллах явцад холбогдох байгууллага, иргэдээс гаргасан санал, хүсэлтэд үндэслэн уг хуульд 4 удаа өөрчлөлт оруулсан бөгөөд одоо ч өөрчлөлт оруулах хууль зүйн болон нийгмийн шаардлага үүсээд байна.

Цагаатгуулах тухай өргөдөл гомдол хүлээн авах хугацаа 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хурлын чуулганаар батлагдсан нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон.

Өргөдөл гаргах хугацаа дууссан болович Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүд, Өргөдлийн байнгын хороо, Засгийн газар болон Засгийн газрын холбогдох байгууллага, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс, нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн салбар комисст хэлмэгдэгчдийн үр хүүхдүүд, холбогдох төрийн бус байгууллагуудаас "хуулийн хугацаанаас хоцорсон, хэрэг материал олдоогүй, Ковид-19 цар тахалтай холбоотой хэрэгжиж эхэлсэн хууль, дүрэм журмууд нөлөөлсөн" зэрэг нөхцөл байдал, шалтгааны улмаас өөрийн гэр бүлийн төрөл төрөгсдийг цагаатгуулж, нэр төрийг сэргээлгэж чадаагүй гэх олон тооны өргөдөл, гомдол, хүсэлтийг ирүүлсэн байх нь хуулийн хугацааг сунгах зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Мөн одоогийн байдлаар 200 орчим иргэн цагаатгуулах тухай өргөдөл гомдлоо гаргаад байна.

Цагаатгуулах тухай гомдол гаргах хуулийн хугацаа дуусгавар болсон тул иргэдээс ирсэн цагаатгуулах тухай өргөдлийг Улсын дээд шүүх, Улсын ерөнхий Прокурор, анхан шатны шүүхүүд хүлээж авахгүй байгаа болович архивт хадгалагдаж байгаа улс төрийн хилс хэрэгт хамааралтай хэргүүдийг шалган шийдвэрлэх ажиллагаа явагдсаар байгаа юм.

1922 оноос 1990 оныг хүртэл нийтдээ 36,000 орчим хүн улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртсөн тухай баримжаа тоо баримт байдаг бөгөөд одоогийн байдлаар 31,460 иргэн хуульд заасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр цагаатгагдаад байна.

Нийт хэлмэгдсэн иргэдийн ихэнхийг цагаатгаад байгаа болович тодорхой нөхцөл байдал, учир шалтгааны улмаас цагаатгуулж амжаагүй иргэдийн эрхийг хуулийн хугацаагаар хязгаарлах нь зохимжгүй бөгөөд эдгээр иргэдэд боломж, боломцоо олгож өгөхийг хүссэн гомдлууд ирсээр байгаа юм.

Иймд Монгол улсын Үндсэн хуульд заасан иргэдийн эрх тэгш байдлыг хангах үүднээс улс төрийн хэлмэгдэгчдийг цагаатгуулах өргөдөл, гомдол хүлээж авах хуулийн хугацааг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгах шаардлагатай байна.

Үндэслэл:

1.1 Хууль зүйн үндэслэл:

Монгол Улсын Үндсэн хуулийн Хүний эрх, эрх чөлөө бүлгийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт "Монгол Улсад оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй" гэж, 14.2 дахь хэсэгт "хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна" гэж, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт "амьд явах эрхтэй, Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно" гэж, 16.12 дахь хэсэгт "төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй" гэж, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэж тус тус заасан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалд: түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалсан уриалгын 2 дугаар зүйлд "Хүн бүр энэ Тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой. Мөн тухайн хүнийг харьяалдаг улс буюу нутаг дэвсгэрийн улс төр, эрх зүй болон олон улсын статус ямар ч байлаа гэсэн, тухайлбал, тусгаар тогтносон буюу асрамжид байгаа, өөрөө эс удирдах зэрэг бүрэн эрхт байдал нь ямар ч байдлаар хязгаарлагдмал байсан тэр нь ялгаварлах үндэс болох ёсгүй" гэж, 3 дугаар зүйлд "Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй" гэж, 5 дугаар зүйлд "Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй" гэж, 7 дугаар зүйлд "Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчлалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Хүн бүр энэхүү Тунхаглалд харшлах аливаа алагчлалаас болон тийнхүү алагчлахыг өдөөсөн турхиралтаас адилхан хамгаалуулах эрхтэй" гэж, 8 дугаар зүйлд "Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй" гэж, 9 дүгээр зүйлд "Хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах буюу хөөн зайлуулах ёсгүй" гэж, 10 дугаар зүйлд "Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй" гэж, 11 дүгээр зүйлийн 1 дүгээрт "Гэмт хэрэгт буруутгагдаж буй хэн боловч өмгөөлөх бүх боломжоор хангагдсан нээлттэй шүүх хурлаар гэм буруутайг нь хуулийн дагуу тогтоох хүртэл гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй", 2 дугаарт "Тухайн үед үндэсний буюу олон улсын хуулийн дагуу гэмт хэрэгт эс тооцож байсан аливаа үйлдэл буюу эс үйлдлийг үндэслэж, хэнийг ч гэмт хэрэгт яллан шийтгэх ёсгүй, гэмт хэрэг гарсан тэр үед ногдуулж болох байснаас илүү хүнд ял тохоож болохгүй" гэж тус тус заажээ.

Дээрх хууль зүйн үндэслэлүүдээр "Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай" хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачилж байна.

1.2 Нийгэм, эдийн засгийн үндэслэл:

2018 оноос хойш Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд заасан журмын дагуу Тагнуулын ерөнхий газрын Тусгай архивын шалгагдаагүй хэргүүд, орон нутгийн архивуудаас татан төвлөрүүлсэн улс төрийн хэргүүд болон 1998 оноос хойш шинээр илэрсэн нөхцөл байдлаар хэрэг үүсгэн шалгаад, улс төрийн хилс хэрэгт холбогдсон гэх ямар нэгэн нотлох баримт тогтоогдоогүйгээс

мөрдөн байцаалтыг зогсоосон хэргүүдийг сэргээж, мөн иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын дагуу шинээр илэрсэн нөхцөл байдлаар хэрэг үүсгэсэн нийт 1,289 хэргийг Улсын Прокурорын ерөнхий газар хянаж, прокурорын тогтоолоор 104 хэргийн 144 хүнийг, Улсын дээд шүүхэд дүгнэлт бичсэнээр 68 хэргийн 79, нийт 223 хүнийг цагаатгаж, 1,146 хэргийн 1,400 орчим хүнийг цагаатгах үндэслэлгүй тул хэвээр буцаасан байна. Одоо 637 хэргийн 1000 орчим хүнд холбогдох үлдэгдэл хэргийг шалгаж дуусгах, цагаатгах, цагаатгуулах гомдол гаргах зэрэг асуудал хуулийн өөрчлөлтийн байдлаас хамааран зогсонги байдалд ороод байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдөр дээрх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6-д заасны дагуу Улсын комиссын жилийн ажлын тайланг авч хэлэлцээд 66/39 дүгээр зөвлөмж гарган цагаатгуулах өргөдөл хүлээн авах болон нөхөх олговор олгох хуулийн хугацааг 2 жилээр сунгах, энэ хугацаанд цагаатгагдаагүй иргэдийн хэргийг шалгаж цагаатгах үүрэг өгсөн байдгаас одоогийн байдлаар:

1. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн боловч хэрэг материал нь бүрэн шалгагдаагүй 451 хэрэг, өмнө шинэ нөхцөл байдлаар шалгаад улс төрийн хэрэгт холбогдсон болох нь нотлох баримтаар тогтоогдоогүй үндэслэлээр мөрдөн байцаалтыг зогсоосон 166 хэрэг, орон нутгийн архиваас татан төвлөрүүлсэн 20 хэрэг, нийт 637 хэргийг бүрэн шалгаж шийдвэрлэх;

2. Улс төрийн шалтгаанаар баривчлагдаж ЗХУ-д шийтгүүлсэн иргэдийн хэргийн материалыг судалж, тэднийг цагаатгах, цагаадсан иргэдийн материалыг татаж авах зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Дээр дурдсан үндэслэл шаардлага болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжөөр өгсөн үүргийг хэрэгжүүлэхийн тулд хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулла.

Хууль батлагдсанаар Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн боловч хэрэг материал нь бүрэн шалгагдаагүй 451 хэрэг, өмнө шинэ нөхцөл байдлаар шалгаад улс төрийн хэрэгт холбогдсон болох нь нотлох баримтаар тогтоогдоогүй үндэслэлээр мөрдөн байцаалтыг зогсоосон 166 хэрэг, орон нутгийн архиваас татан төвлөрүүлсэн 20 хэрэг, нийт 637 хэргийг бүрэн шалгаж цагаатгагдах, улс төрийн шалтгаанаар баривчлагдаж ЗХУ-д шийтгүүлсэн иргэдийн хэргийн материалыг судалж, тэднийг цагаатгах, цагаадсан иргэдийн материалыг татаж авах эрх зүйн орчин бүрдэж улс төрийн хэлмэгдүүлэлтийн улмаас нийгэмд учирсан хор хохирол, үүсэж бий болсон шалтгаан нөхцлийг тодорхойлох, хэлмэгдэгчдийг цагаатгах, нэр төрийг сэргээх, дурсгалыг мөнхжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах болно.

**Хоёр. "Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль"-ийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

2.1 "Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль"-ийн төсөл нь цагаатгуулах гомдлыг хүлээн авах хуулийн хугацааг сунгаж, тодорхой нөхцөл байдал, учир шалтгааны улмаас цагаатгуулж амжаагүй иргэдийн эрхийг хангах, эдгээр иргэдийн эрхзүйн асуудлыг шийдвэрлэх зорилготой юм.

2.2 Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулна.

2.2.1 Өөрчлөлтийг "Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай" хуулийн хоёрдугаар бүлэг, 6 дугаар зүйлийн 6.3-т тусгана.

2.2.2 "Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль"-ийн төсөл нь нэг зүйлтэй байх бөгөөд дараах агуулгатай байна.

1/ Цагаатгуулах тухай гомдлыг ..... оны .... дугаар сарын .... -ны өдрийн дотор гаргаж болох бөгөөд энэ хугацаанаас хойш гаргасан гомдлыг хүлээж авахгүй"

2.3 "Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль"-ийн хамрах хүрээ нь энэ хуулийн 2 дугаар бүлгийн 4 ба 5 дугаар зүйлд заасан "Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгч" гэж тооцогдох Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн байна.

2.4 "Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгч" өөрөө буюу түүний гэр бүлийн аль нэг гишүүн, хууль ёсны төлөөлөгч, түүнчлэн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс, түүний орон нутгийн салбар комиссын хүсэлтээр цагаатгуулах үйл ажиллагаа явагдана.

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засгийн үр дагавар**

"Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль"-ийн төслийг баталж, мөрдүүлэх нь дараах үр дагавартай:

3.1 Монгол Улсын Үндсэн хуулийн хүний эрх, эрх чөлөө бүлэгт заасан хүн бүр хууль шүүхийн өмнө тэгш эрхтэй байх нийгэм улс төрийн баталгаа хангана.

3.2 Хуулийн таатай орчин бүрдэж иргэдэд хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

3.3 Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн гэх иргэдийг нэг мөр цагаатгаж, нэр төрийг сэргээснээр улс төрийн хэлмэгдүүлэлтийн хор уршгийг өөрийн биеэр мэдэрч бие махбодь, сэтгэл санааны хэлмэгдүүлэлтэд өртсөн хэлмэгдэгч болон дам хэлмэгдэлтэд өртөж сэтгэл санааны хохиролд хамгийн ихээр өртсөн түүний гэр бүлийн гишүүдийн гомдол шийдвэрлэгдэнэ.

3.4 Хуулийн өөрчлөлтөөр нөхөх олговортой холбогдох хуулийн зохицуулалт хөндөгдөхгүй тул Улсын төвлөрсөн төсөвт ямар нэг байдлаар дарамт, нөлөөлөл үүсэхгүй.

3.5 Сунгасан хугацаанд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд зааснаар хэлмэгдсэн иргэдийг цагаатгах, цагаатгагдсан иргэдийн дурсгалыг мөнхжүүлэх, сөён гэгээрүүлэх гэх мэт зохих ажлуудыг гүйцэтгэж нийгэмд хэлмэгдүүлэлтийн хор уршгийг таниулна.

3.6 Цагаатгуулах гомдлыг хүлээн авах хуулийн үйлчлэх хугацааг сунгаснаар улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн талаар гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

3.7 Хууль батлагдсанаар улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн боловч хэрэг материал нь бүрэн шалгагдаагүй 451 хэрэг, өмнө шинэ нөхцөл байдлаар шалгаад улс төрийн хэрэгт холбогдсон болох нь нотлох баримтаар тогтоогдоогүй үндэслэлээр мөрдөн байцаалтыг зогсоосон 166 хэрэг, орон нутгийн архиваас татан төвлөрүүлсэн 20 хэрэг, нийт 637 хэргийг бүрэн шалгаж цагаатгагдах, улс төрийн шалтгаанаар баривчлагдаж ЗХУ-д шийтгүүлсэн иргэдийн хэргийн материалыг судалж, тэднийг цагаатгах, цагаадсан иргэдийн материалыг татаж авах асуудлыг шийдвэрлэх боломжтой болно.

**Дөрөв. Хуульд өөрчлөлт оруулах тухай төсөл Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглалд хэрхэн уялдах талаар болон, цаашид өөрчлөлт оруулах, хүчингүй болох хуулийн талаар**

Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомж, Хүний эрхийн түгээмэл тунхаглалд нийцсэн байна. Уг хууль батлагдсанаар өөр бусад шинээр боловсруулах болон өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль байхгүй байна.

## УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙГ ЦАГААТГАХ, ТЭДЭНД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

20... оны ... дугаар сарын ... Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлаас Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийг 1998 онд баталсан бөгөөд цагаатгуулах тухай гомдол гаргах хугацааг 2018 онд хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 4 дэх удаагаа сунгасан байна. Хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, цагаатгуулах тухай гомдлыг хүлээж авах хугацаа 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болсон. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийн нэр төрийг сэргээн цагаатгах, дурсгалыг мөнхжүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг уг хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллагууд улс, аймаг, нийслэлийн хэмжээнд хариуцан, хэрэгжүүлж хуулийн биелэлтийг хангуулан ажиллаж байна.

Цагаатгуулах тухай гомдол гаргах хуулийн хугацаа дуусгавар болсныг үндэслэн иргэдээс ирсэн цагаатгуулах тухай өргөдлийг Улсын дээд шүүх, Улсын ерөнхий Прокурор, анхан шатны шүүхүүд хүлээж авахгүй байгаа боловч архивт хадгалагдаж байгаа улс төрийн хилс хэрэгт хамааралтай хэргүүдийг шалган шийдвэрлэх ажиллагаа явагдсаар байгаа юм.

Тагнуулын ерөнхий газрын бүрэн бус мэдээгээр 1922-1990 оны хооронд улс төрийн хилс хэрэгт 36,000 орчим хүн хэлмэгдсэн гэгддэг бөгөөд 1939 оноос өнөөг хүртэл нийтдээ 31,460 хүн цагаатгагдсаны 27,323 нь Улсын комисс байгуулагдсан 1990 оноос хойш хугацаанд цагаатгагджээ.

Нийт цагаатгагдсан иргэдийн 20,325 хуулийн дээд хэмжээ буюу буудан алах, 8,058 хорих ял, 43 тэнсэн харгалзах, 5 торгох ялаар шийтгүүлсэн байдаг бол 177 хэлмэгдэгч хоригдож, мөрдөгдөж байх хугацаандаа суллагдсан, 83 хэлмэгдэгч шоронд нас барсан, 1,763 ял тодорхойгүй, 461 таслан шийтгэсэн тогтоолгүй, 279 баривчлагдсан, 266 хэлмэгдэгч нам захиргааны байгууллагын шийдвэрээр ажил албан тушаалаасаа халагдаж, нутаг заагдан цөлөгдөх шийтгэл хүлээсэн байдаг.

Одоогийн байдлаар иргэдээс 200 орчим иргэнийг цагаатгуулах тухай өргөдөл, гомдлыг Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын ажлын албанд ирүүлээд байна.

Цагаатгуулах тухай өргөдөл гаргах хугацаа дууссан боловч Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүд, Өргөдлийн байнгын хороо, Засгийн газар болон Засгийн газрын холбогдох байгууллага, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс, нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн салбар комисст хэлмэгдэгчдийн үр хүүхдүүд, ах, дүү нар болон холбогдох төрийн бус байгууллагуудаас өөрийн гэр бүлийн гишүүн, төрөл төрөгсдийг цагаатгуулж чадаагүй, хуулийн хугацаанаас хоцорсон, хэрэг материал олдоогүй, Ковид-19 цар тахалтай холбоотой хэрэгжиж эхэлсэн хууль, дүрэм журмууд нөлөөлсөн зэрэг нөхцөл байдал, шалтгааны улмаас иргэдээ цагаатгуулж, нэр төрийг сэргээлгэж чадаагүй гэх утга бүхий олон тооны өргөдөл, гомдол, хүсэлтийг ирүүлсэн байх нь хуулийн хугацааг сунгах зайлшгүй шаардлагыг бий болгоод байна.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг тусгасан. Үүнд:

1.Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтад улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн гэж

үзэж байгаа этгээдийг цагаатгуулах тухай гомдлыг хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 2 жилийн хугацаанд хүлээж авах бөгөөд энэ хугацаанаас хойш гаргасан өргөдөл гомдлыг хүлээж авахгүй байхаар төсөлд тусгасан.

Ингэснээр Тагнуулын ерөнхий газрын Тусгай архивд хадгалагдаж байгаа хэргийг шалгаж дуусгах, хэлмэгдсэн иргэдийг цагаатгах тухай асуудал бүр мөсөн шийдвэрлэгдэх эрх зүйн орчин бүрдэнэ.

ХУУЛИЙН ТӨСӨЛ САНААЧЛАГЧ

## ТОЙМ АГУУЛГА

1. Оршил
2. Тайлангийн I хэсэг: */Урьдчилан тандан судалсан байдал/*
3. Тайлангийн II хэсэг: */Хуулийн төслийн үр нөлөөний талаар[1]/*
4. Тайлангийн III хэсэг: */Хууль, тогтоолоор зохицуулах зайлшгүй шаардлага/*
5. Хуулийн төслийн уялдаа холбоо
6. Нэгдсэн дүгнэлт
7. Ашигласан материал

### Нэг. Оршил

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал"-ыг баримтлан боловсруулсан бөгөөд хуулийн төслийн хэрэгцээ, шаардлага, үр нөлөө, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал", "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал", "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал"-ын дагуу боловсруулав.

### Хоёр. Урьдчилсан тандан судалгаа

Хуулийн төслийг боловсруулахдаа Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжид нийцсэн байдлыг шалгуур үзүүлэлтээр[2] тандан судалсан бөгөөд хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг судлав.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хийдэл, зөрчлийг арилган хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулах зорилгоор хуулийн төслийн үр нөлөөг үнэлэв.

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй бөгөөд энэхүү хуулийн төсөл улсын төвлөрсөн төсөвт ямар нэгэн байдлаар дарамт, нөлөөлөл учруулахгүй зөвхөн тухайн иргэнийг цагаатгаж, нэр төрийг нь сэргээх юм. Хуулийн төсөл хэрэгжиж эхэлсэн тохиолдолд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд заасан цагаатгах үйл ажиллагаа явуулах байгууллагууд болон хуулийн хэрэгжилт, биелэлтийг хангах Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын үйл ажиллагааны зардалд багтах юм.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан өөрчлөлт нь Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын ажлын албаны орон тоонд ямар нэгэн байдлаар нөлөөлөхгүй одоогийн хүний нөөцөөр ажиллах боломжтой.

---

[1] Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"

[2] Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал"

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг "Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах" шалгах хэрэгслийн хүрээнд дараах асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог тогтоов.

**Гурав. Хуулийн төслийн үр нөлөөний талаар**[1]

Хүснэгт 1

## ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

| Үзүүлэх үр нөлөө | Холбогдох асуулт | Хариулт | | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх | 1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх | | | |
| | 1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх | Тийм | Үгүй √ | |
| | 1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх | Тийм | Үгүй √ | |
| | 1.1.3. Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 1.2.Оролцоог хангах | | | |
| | 1.2.1. Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх | Тийм √ | Үгүй | |
| | 1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага | | | |
| | 1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх | Тийм √ | Үгүй | |
| | 1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх | Тийм √ | Үгүй | |
| | 1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх | Тийм | Үгүй √ | |
| 2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх | 2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх | Тийм | Үгүй | Нөлөөлөхгүй |
| | 2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх | Тийм | Үгүй | Нөлөөлөхгүй |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3.Эрх агуулагч[8] | 3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх | Тийм | Үгүй | Нөлөөлөхгүй |
| | 3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх | Тийм | Үгүй √ | |
| | 3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй) | Тийм | Үгүй | Нөлөөлөхгүй |
| 4.Үүрэг хүлээгч[9] | 4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх | Тийм | Үгүй | Нөлөөлөхгүй |
| 5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх | 5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх | Тийм | Үгүй | Нөлөөлөхгүй |
| | 5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх | Тийм | Үгүй | Нөлөөлөхгүй |

Хүснэгт 2

## ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

| Үзүүлэх үр нөлөө | Холбогдох асуулт | Хариулт | | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар | 1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | Нөлөөлөхгүй |
| | | Тийм | Үгүй√ | |
| | 1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан) | Тийм | Үгүй√ | |
| | 1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх | Тийм | Үгүй√ | |
| 2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал | 2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх | Тийм | Үгүй√ | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал | 3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал | 4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх | Тийм | Үгүй√ | |
| 5.Өмчлөх эрх | 5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх | Тийм | Үгүй√ | |
| 6.Инноваци болон судалгаа шинжилгээ | 6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх | Тийм | Үгүй | Нөлөөлөхгүй |
| | 6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх | Тийм | Үгүй | Нөлөөлөхгүй |
| 7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв | 7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй | Нөлөөлөхгүй |
| | 7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх | Тийм | Үгүй | Нөлөөлөхгүй |
| | 7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй | Нөлөөлөхгүй |
| | 7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 8.Тодорхой бүс нутаг, салбарууд | 8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 9.Төрийн захиргааны байгууллага | 9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх | Тийм | Үгүй√ | |
| 10.Макро эдийн засгийн хүрээнд | 10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 10.3.Инфляци нэмэгдэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 11.Олон улсын харилцаа | 11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх | Тийм√ | Үгүй | |

Хүснэгт 3

## НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

| Үзүүлэх үр нөлөө | Холбогдох асуулт | Хариулт | | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл | 1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх | 2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх | Тийм | Үгүй√ | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал | 3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт | Тийм | Үгүй√ | |
| | 3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун | 4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх | Тийм√ | Үгүй | |
| | 4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал | 5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем | 6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсрролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал | 7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 8.Соёл | 8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |

Хүснэгт 4

## БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

| Үзүүлэх үр нөлөө | Холбогдох асуулт | Хариулт | | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1.Агаар | 1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 2.Зам тээвэр, түлш, эрчим хүч | 2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 3.Ан амьтан, ургамлыг хамгаалах | 3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 4.Усны нөөц | 4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 5.Хөрсний бохирдол | 5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 6.Газрын ашиглалт | 6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг | 7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх | Тийм | Үгүй√ | |

**Дөрөв. Хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагын талаар[3]**

Монгол Улсын Их Хурлаас Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийг 1998 онд баталсан бөгөөд уг хуулийн дагуу улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийн нэр төрийг сэргээн цагаатгах, тэдэнд тусламж дэмжлэг үзүүлэн нөхөх олговор олгох, дурсгалыг мөнхжүүлэх ажлыг хийж байна.

Тагнуулын ерөнхий газрын бүрэн бус мэдээгээр 1922-1990 оны хооронд улс төрийн хилс хэрэгт 36,000 орчим хүн хэлмэгдсэн гэгддэг бөгөөд 1939 оноос өнөөг хүртэл нийтдээ 31,460 хүн цагаатгагдсаны 27,323 нь Улсын комисс байгуулагдсан 1990 оноос хойш хугацаанд цагаатгагджээ.

Нийт цагаатгагдсан иргэдийн 20,325 хуулийн дээд хэмжээ буюу буудан алах, 8,058 хорих ял, 43 тэнсэн харгалзах, 5 торгох ялаар шийтгүүлсэн байдаг бол 177 хэлмэгдэгч хоригдож, мөрдөгдөж байх хугацаандаа суллагдсан, 83 хэлмэгдэгч шоронд нас барсан, 1,763 ял тодорхойгүй, 461 таслан шийтгэсэн тогтоолгүй, 279 баривчлагдсан, 266 хэлмэгдэгч нам, захиргааны байгууллагын шийдвэрээр ажил, албан тушаалаасаа халагдаж, нутаг заагдан цөлөгдөх шийтгэл хүлээсэн байдаг.

1. Өргөдөл гаргах хугацаа дууссан боловч Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүд, Өргөдлийн байнгын хороо, Засгийн газар болон Засгийн газрын холбогдох байгууллага, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс, нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн салбар комисст хэлмэгдэгчдийн үр хүүхдүүд, холбогдох төрийн бус байгууллагуудаас "хуулийн хугацаанаас хоцорсон, хэрэг материал олдоогүй, Ковид-19 цар тахалтай холбоотой хэрэгжиж эхэлсэн хууль, дүрэм журмууд нөлөөлсөн" зэрэг нөхцөл байдал,

[3] Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал"

шалтгааны улмаас өөрийн гэр бүлийн төрөл төрөгсдийг цагаатгуулж, нэр төрийг сэргээлгэж чадаагүй гэх олон тооны өргөдөл, гомдол, хүсэлтийг ирүүлсэн байх нь хуулийн хугацааг сунгах зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Одоогийн байдлаар 200 орчим иргэн цагаатгуулах тухай өргөдөл гомдлоо гаргаад байна.

2. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн боловч хэрэг материал нь бүрэн шалгагдаагүй 451 хэрэг, өмнө шинэ нөхцөл байдлаар шалгаад улс төрийн хэрэгт холбогдсон болох нь нотлох баримтаар тогтоогдоогүй үндэслэлээр мөрдөн байцаалтыг зогсоосон 166 хэрэг, орон нутгийн архиваас татан төвлөрүүлсэн 20 хэрэг, нийт 637 хэргийг бүрэн шалгаж шийдвэрлэх;

3. Улс төрийн шалтгаанаар баривчлагдаж ЗХУ-д шийтгүүлсэн иргэдийн хэргийн материалыг судалж, тэднийг цагаатгах, цагаадсан иргэдийн материалыг татаж авах зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Дээрх дурьдсан асуудлаар өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

**Тав. Хуулийн төслийн уялдаа холбоо**

| № | "Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах"асуулт | Хариулт, тайлбар |
|---|---|---|
| 1. | Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх; | Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт "Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгаж нэр төрийг нь сэргээх, тэдэнд нөхөх олговор олгох, улс төрийн хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаврыг арилгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино." гэж тодорхойлсон бөгөөд хуулийн төсөлд тусгасан зохицуулалт нь улс төрийн хэлмэгдүүлэлтийн үр дагаврыг арилгах, Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгаж нэр төрийг нь сэргээх гэсэн зорилттой нийцэж байна. |
| 2. | Хуулийн төслийн "Хууль тогтоомж" гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх; | Хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл бөгөөд энэхүү төсөлд хамаарахгүй. |
| 3. | Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх; | Хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл бөгөөд энэхүү төсөлд хамаарахгүй. |
| 4. | Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх; | Нийцэж байгаа болно. |
| 5. | Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх; | Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардаагүй. |

| | | |
|---|---|---|
| 6. | Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх; | Хуулийн төсөлд хуулийг хэрэгжүүлэх этгээдийн нэрийг одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид тусгасан. |
| 7. | Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх; | Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулаагүй. |
| 8. | Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх; | Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгаагүй. |
| 9. | Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх; | Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгаагүй. |
| 10. | Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх; | Тогтоогоогүй. |
| 11. | Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх; | Тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгаагүй. |
| 12. | Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх; | Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт байхгүй. |
| 13. | Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх; | Жендэрийн эрх тэгш байдлыг хөндсөн зохицуулалт байхгүй. |
| 14. | Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх; | Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй. |
| 15. | Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх; | Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй. |
| 16. | Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх. | Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээ тусгагдаагүй. |

**Зургаа. Дүгнэлт**

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалаар хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлага, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо, хууль тогтоомжийн уялдаа холбоог нягтлан шалгасан бөгөөд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай нийцсэн байна.

Түүнчлэн Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь улсын төсөвт зардал үүсгэхгүй бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль болон Хүний эрхийн түгээмэл тунхаглалын зүйл заалтуудтай нийцэж буй учир дараах зэрэг үр дагаврыг бий болгож байна. Үүнд:

- Цагаатгах ажил хуульд заасан хугацааны дагуу цаашид үргэлжлэн хэлмэгдсэн иргэдийг цагаатгах, нэр төрийг нь сэргээх эрх зүйн орчин бүрдэнэ.

- Хуулийн зүйл, заалтад шаардлагатай өөрчлөлтийг оруулснаар хууль хоорондын зөрчил арилна.

- Хуулийн үйлчлэх хугацааг сунгаж, хууль батлагдсанаар улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн боловч хэрэг материал нь бүрэн шалгагдаагүй 451 хэрэг, өмнө шинэ нөхцөл байдлаар шалгаад улс төрийн хэрэгт холбогдсон болох нь нотлох баримтаар тогтоогдоогүй үндэслэлээр мөрдөн байцаалтыг зогсоосон 166 хэрэг, орон нутгийн архиваас татан төвлөрүүлсэн 20 хэрэг, нийт 637 хэргийг бүрэн шалгаж цагаатгагдах, улс төрийн шалтгаанаар баривчлагдаж ЗХУ-д шийтгүүлсэн иргэдийн хэргийн материалыг судалж, тэднийг цагаатгах, цагаадсан иргэдийн материалыг татаж авах эрх зүйн орчин бүрдэж улс төрийн хэлмэгдүүлэлтийн улмаас нийгэмд учирсан хор хохирол, үүсэж бий болсон шалтгаан нөхцөл, хэлмэгдэгсдийг цагаатгах, нэр төрийг сэргээх, дурсгалыг мөнхжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах болно.

**Долоо. Ашигласан материал**


1. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай Монгол Улсын хууль /2018 он/

2. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал"

3. Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын "Мэдээллийн нэгдсэн сан"-гийн мэдээлэл

4. Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын 20, 25 жилийн тайлангийн эмхэтгэл /2010 он, 2015 он/

5. Монгол Улсын Дээд Шүүх болон Улсын Ерөнхий Прокурорын газраас ирүүлсэн цагаатгагдсан иргэдийн мэдээлэл

6. Бусад материал

7. Legalinfo.mn


МОНГОЛ УЛСЫН ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИСС

## Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судалсан байдал

Хуулийн төслийг боловсруулахдаа Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжид нийцсэн байдлыг шалгуур үзүүлэлтээр[1] тандан судалсан бөгөөд хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг харуулав.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилган, хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулах зорилгоор хуулийн төслийн үр нөлөөг үнэлэв.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн төсөлд "Зардлын тооцоо", "Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах" гэсэн шалгуур үзүүлэлтийг[2] сонгосон бөгөөд хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгож, зардлын тооцоо шалгуур үзүүлэлтэд тохирох заалтуудыг[3] бүхэлд нь сонгон зардлын тооцоог хийв.

| № | Шалгуур үзүүлэлт | Тохирох шалгах хэрэгсэл |
|---|---|---|
| 1 | Зорилгод хүрэх байдал | Зорилгод дүн шинжилгээ хийх |
| 2 | Практикт хэрэгжих боломж | Практикт турших |
| 3 | Ойлгомжтой байдал | Ойлгомжтой байдлыг шалгах |
| 4 | Хүлээн зөвшөөрөгдөх байдал | Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх |
| 5 | Зардал | Зардлын тооцоо хийх |
| 6 | Харилцан уялдаа | Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах |

[1] *Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар* баталсан "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал"

[2] *Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар* баталсан "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал", 2.2.Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх үндсэн шалгуур үзүүлэлт дараах төрөлтэй байна:

2.2.1.зорилгод хүрэх байдал;
2.2.2.практикт хэрэгжих боломж;
2.2.3.ойлгомжтой байдал;
2.2.4.хүлээн зөвшөөрөгдөх байдал;
2.2.5.зардал;
2.2.6.харилцан уялдаа.
2.7."Зардал" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон улсын төсөвт ачаалал, хөнгөлөлтийг үүсгэх, төрийн байгууллагад хуулийн төслийг хэрэгжүүлэхэд үүсэх зардал, уг зардлын улмаас үүсэх үр дагавар зэргийг тооцон судална.

[3] *Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар* баталсан "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал", Дөрөв. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх 4.1.Энэ үе шатанд шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлнэ.

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

## УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙГ ЦАГААТГАХ ТЭДЭНД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/ 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг:**

"6.3. Цагаатгуулах тухай гомдлыг энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 2 жилийн дотор гаргаж болох бөгөөд энэ хугацаанаас хойш гаргасан гомдлыг хүлээж авахгүй."

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2023 оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Хуулийн өөрчлөлтөөр зөвхөн Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийг цагаатгах, нэр төрийг сэргээх бөгөөд нөхөх олговор олгох тухай асуудал хөндөгдөхгүй учир Улсын төсөвт ачаалал үүсгэхгүй.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт оруулах өөрчлөлт нь Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын ажлын албаны тухайн жилийн үйл ажиллагааны төсөв болон орон тоонд ямар нэгэн байдлаар нөлөөлөхгүй одоогийн хүний нөөцөөр ажиллах боломжтой.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг "Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах" шалгах хэрэгслийн хүрээнд дараах асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог тогтоов.

| № | "Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах"асуулт | Хариулт, тайлбар |
|---|---|---|
| 1. | Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх; | Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт "Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн хилс хэрэгт |

| | | |
|---|---|---|
| | | хэлмэгдэгчдийг цагаатгаж нэр төрийг нь сэргээх, улс төрийн хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаврыг арилгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино." гэж тодорхойлсон бөгөөд хуулийн төсөлд тусгасан зохицуулалт нь улс төрийн хэлмэгдүүлэлтийн үр дагаврыг арилгах, Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгаж нэр төрийг нь сэргээх гэсэн зорилттой нийцэж байна. |
| 2. | Хуулийн төслийн "Хууль тогтоомж" гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх; | Хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл бөгөөд энэхүү төсөлд хамаарахгүй. |
| 3. | Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх; | Хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл бөгөөд энэхүү төсөлд хамаарахгүй. |
| 4. | Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх; | Нийцэж байгаа болно. |
| 5. | Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх; | Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардаагүй. |
| 6. | Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх; | Хуулийн төсөлд хуулийг хэрэгжүүлэх этгээдийн нэрийг одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид тусгасан. |
| 7. | Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх; | Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулаагүй. |
| 8. | Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх; | Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгаагүй. |
| 9. | Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх; | Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгаагүй. |
| 10. | Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх; | Тогтоогоогүй. |
| 11. | Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх; | Тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгаагүй. |

| | | |
|---|---|---|
| 12. | Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх; | Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт байхгүй. |
| 13. | Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх; | Жендэрийн эрх тэгш байдлыг хөндсөн зохицуулалт байхгүй. |
| 14. | Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх; | Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй. |
| 15. | Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх; | Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй. |
| 16. | Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх. | Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээ тусгагдаагүй. |

## Дүгнэлт

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалаар хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлага, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо, хууль тогтоомжийн уялдаа холбоог нягтлан шалгасан бөгөөд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль бусад хуультай нийцсэн байна.

Түүнчлэн Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь улсын төсөвт зардал үүсгэхгүй бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль болон Хүний эрхийн түгээмэл тунхаглалын зүйл заалтуудтай нийцэж буй учир дараах эерэг үр дагаврыг бий болгож байна. Үүнд:

- Цагаатгах ажил хуульд заасан хугацааны дагуу цаашид үргэлжлэн хэлмэгдсэн иргэдийг цагаатгах, нэр төрийг нь сэргээх эрх зүйн орчин бүрдэнэ.

- Хуулийн зүйл, заалтад шаардлагатай өөрчлөлтийг оруулснаар хууль хоорондын зөрчил арилна.

- Хуулийн үйлчлэх хугацааг сунгаж, хууль батлагдсанаар улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн гэх этгээдийг цагаатгуулах тухай өргөдөл, гомдлыг шийдвэрлэх болон улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн боловч хэрэг материал нь бүрэн шалгагдаагүй 451 хэрэг, өмнө шинэ нөхцөл байдлаар шалгаад улс төрийн хэрэгт холбогдсон болох нь нотлох баримтаар тогтоогдоогүй үндэслэлээр мөрдөн байцаалтыг зогсоосон 166 хэрэг, орон нутгийн архиваас татан төвлөрүүлсэн 20 хэрэг, нийт 637 хэргийг бүрэн шалгаж цагаатгагдах, улс төрийн шалтгаанаар баривчлагдаж ЗХУ-д шийтгүүлсэн иргэдийн хэргийн материалыг судалж, тэднийг цагаатгах, цагаадсан иргэдийн материалыг татаж авах эрх зүйн орчин бүрдэж улс төрийн хэлмэгдүүлэлтийн улмаас нийгэмд учирсан хор хохирол, үүсэж бий болсон шалтгаан нөхцөл, хэлмэгдэгсдийг цагаатгах, нэр төрийг сэргээх, дурсгалыг мөнхжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах болно.

## Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал

## ҮР НӨЛӨӨ, ҮНЭЛГЭЭ

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилган хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулах зорилгоор хуулийн төслийн үр нөлөөг үнэлдэг.

Хуулийн төслийг боловсруулахдаа Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжид нийцсэн байдлыг шалгуур үзүүлэлтээр[1] тандан судалсан бөгөөд хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг доорх байдлаар үнэлэв.

Үүнд:

1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө */хүснэгт 1/*
2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө */хүснэгт 2/*
3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө */хүснэгт 3/*
4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө */хүснэгт 4/*

Хүснэгт 1

### ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

| Үзүүлэх үр нөлөө | Холбогдох асуулт | Хариулт | | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх | 1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх | | | |
| | 1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх | Тийм | Үгүй √ | |
| | 1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх | Тийм | Үгүй √ | |
| | 1.1.3. Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 1.2.Оролцоог хангах | | | |
| | 1.2.1. Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх | Тийм | Үгүй√ | |

[1] *Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан* "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал"

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх | Тийм √ | Үгүй | |
| | 1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага | | | |
| | 1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх | Тийм √ | Үгүй | |
| | 1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх | Тийм √ | Үгүй | |
| | 1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх | Тийм | Үгүй √ | |
| 2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх | 2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх | Тийм | Үгүй | Нөлөөлөхгүй |
| | 2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх | Тийм | Үгүй | Нөлөөлөхгүй |
| 3.Эрх агуулагч[8] | 3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх | Тийм | Үгүй | Нөлөөлөхгүй |
| | 3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх | Тийм | Үгүй √ | |
| | 3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй) | Тийм | Үгүй | Нөлөөлөхгүй |
| 4.Үүрэг хүлээгч[9] | 4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх | Тийм | Үгүй | Нөлөөлөхгүй |
| 5.Жендэрийн | 5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх | Тийм | Үгүй | Нөлөөлөхгүй |

| | | | | |
|---|---|---|---|---|
| эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх | 5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх | Тийм | Үгүй | Нөлөөлөхгүй |

Хүснэгт 2

## ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

| Үзүүлэх үр нөлөө | Холбогдох асуулт | Хариулт | | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар | 1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | Нөлөөлөхгүй |
| | | Тийм | Үгүй√ | |
| | 1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан) | Тийм | Үгүй√ | |
| | 1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх | Тийм | Үгүй√ | |
| 2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал | 2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх | Тийм | Үгүй√ | |
| 3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал | 3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсоох хүргэх эсэх | Тийм | Үгүй√ | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал | 4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх | Тийм | Үгүй√ | |
| 5.Өмчлөх эрх | 5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх | Тийм | Үгүй√ | |
| 6.Инноваци болон судалгаа шинжилгээ | 6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх | Тийм | Үгүй | Нөлөөлөхгүй |
| | 6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх | Тийм | Үгүй | Нөлөөлөхгүй |
| 7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв | 7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй | Нөлөөлөхгүй |
| | 7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх | Тийм | Үгүй | Нөлөөлөхгүй |
| | 7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй | Нөлөөлөхгүй |
| | 7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 8.Тодорхой бүс нутаг, салбарууд | 8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 9.Төрийн захиргааны байгууллага | 9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх | Тийм | Үгүй√ | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 10.Макро эдийн засгийн хүрээнд | 10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 10.3.Инфляци нэмэгдэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 11.Олон улсын харилцаа | 11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх | Тийм√ | Үгүй | |

Хүснэгт 3

## НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

| Үзүүлэх үр нөлөө | Холбогдох асуулт | Хариулт | | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл | 1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх | 2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх | Тийм | Үгүй√ | |
| 3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал | 3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн | Тийм | Үгүй√ | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт | | | |
| | 3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун | 4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх | Тийм√ | Үгүй | |
| | 4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал | 5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем | 6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсрролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал | 7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 8.Соёл | 8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |

Хүснэгт 4

## БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

| Үзүүлэх үр нөлөө | Холбогдох асуулт | Хариулт | | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1.Агаар | 1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 2.Зам тээвэр, түлш, эрчим хүч | 2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 3.Ан амьтан, ургамлыг хамгаалах | 3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх | Тийм | Үгүй√ | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 4.Усны нөөц | 4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 5.Хөрсний бохирдол | 5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 6.Газрын ашиглалт | 6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх | Тийм | Үгүй√ | |
| 7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг | 7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх | Тийм | Үгүй√ | |
| | 7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх | Тийм | Үгүй√ | |

МОНГОЛ УЛСЫН ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИСС

## Хууль тогтоомжоор зохицуулах шаардлага

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал"-ыг баримтлан боловсруулсан бөгөөд хуулийн төслийн хэрэгцээ, шаардлага, үр нөлөө, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал", "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал", "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал"-ын дагуу боловсруулав.

## Нэг. Хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагын талаар[1]

Монгол Улсын Их Хурлаас Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийг 1998 онд баталсан бөгөөд уг хуулийн дагуу улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийн нэр төрийг сэргээн цагаатгах, тэдэнд тусламж дэмжлэг үзүүлэн нөхөх олговор олгох, дурсгалыг мөнхжүүлэх ажлыг хийж байна.

Тагнуулын ерөнхий газрын бүрэн бус мэдээгээр 1922-1990 оны хооронд улс төрийн хилс хэрэгт 36,000 орчим хүн хэлмэгдсэн гэсэн тоо баримт байдаг бөгөөд 1939 оноос өнөөг хүртэл нийтдээ 31,460 хүн цагаатгагдсаны 27,323 нь Улсын комисс байгуулагдсан 1990 оноос хойш хугацаанд цагаатгагджээ.

Нийт цагаатгагдсан иргэдийн 20,325 хуулийн дээд хэмжээ буюу буудан алах, 8,058 хорих ял, 43 тэнсэн харгалзах, 5 торгох ялаар шийтгүүлсэн байдаг бол 177 хэлмэгдэгч хоригдож, мөрдөгдөж байх хугацаандаа суллагдсан, 83 хэлмэгдэгч шоронд нас барсан, 1,763 ял тодорхойгүй, 461 таслан шийтгэсэн тогтоолгүй, 279 баривчлагдсан, 266 хэлмэгдэгч нам захиргааны байгууллагын шийдвэрээр ажил албан тушаалаасаа халагдаж, нутаг заагдан цөлөгдөх шийтгэл хүлээсэн байдаг.

Одоогийн байдлаар иргэдээс 200 орчим иргэнийг цагаатгуулах тухай өргөдөл, гомдлыг Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын ажлын албанд ирүүлээд байна.

Цагаатгуулах тухай өргөдөл гаргах хугацаа дууссан боловч Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүд, Өргөдлийн байнгын хороо, Засгийн газар болон Засгийн газрын холбогдох байгууллага, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс, нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн салбар комисст хэлмэгдэгчдийн үр хүүхдүүд, ах, дүү нар болон холбогдох төрийн бус байгууллагуудаас өөрийн гэр бүлийн гишүүн, төрөл төрөгсдийг цагаатгуулж чадаагүй, хуулийн хугацаанаас хоцорсон, хэрэг материал олдоогүй, Ковид-19 цар тахалтай холбоотой хэрэгжиж эхэлсэн хууль, дүрэм журмууд нөлөөлсөн зэрэг нөхцөл байдал, шалтгааны улмаас иргэдээ цагаатгуулж, нэр төрийг сэргээлгэж чадаагүй гэх утга бүхий олон тооны өргөдөл, гомдол, хүсэлтийг ирүүлсэн байх нь хуулийн хугацааг сунгах зайлшгүй шаардлагыг бий болгоод байна.

---

[1] *Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар* баталсан "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал"

Учир нь хэлмэгдсэн иргэд, тэдгээрийн одоо амьд сэрүүн байгаа төрсөн хүүхдүүд болон ач зээ, гэр бүлийн бусад гишүүд улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэж, нэр төрөө алдаж, тухайн цаг үеийнхээ нийгэмд эсэргүүний гэр бүл хэмээн адлагдан байнга хараа хяналттай байж, эрх нь хязгаарлагдаж байсны улмаас сургуульд сурах, ажил хөдөлмөр эрхлэх зэрэг боломжуудаа алдаж байсан зэргээс шалтгаалан одоо хүртэл сэтгэл санааны хувьд эмзэглэлтэй байдаг бөгөөд хэлмэгдсэн иргэнээ цагаатгуулж нэр төрийг нь сэргээх туйлын хүсэлтэй байна. Түүнчлэн

1. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн боловч хэрэг материал нь бүрэн шалгагдаагүй 451 хэрэг, өмнө шинэ нөхцөл байдлаар шалгаад улс төрийн хэрэгт холбогдсон болох нь нотлох баримтаар тогтоогдоогүй үндэслэлээр мөрдөн байцаалтыг зогсоосон 166 хэрэг, орон нутгийн архиваас татан төвлөрүүлсэн 20 хэрэг, нийт 637 хэргийг бүрэн шалгаж шийдвэрлэх;

2. Улс төрийн шалтгаанаар баривчлагдаж ЗХУ-д шийтгүүлсэн иргэдийн хэргийн материалыг судалж, тэднийг цагаатгах, цагаадсан иргэдийн материалыг татаж авах зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Дээр дурдсан үндэслэл шаардлагын дагуу хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулллаа.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд "Зардлын тооцоо", "Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах" гэсэн шалгуур үзүүлэлтийг[2] сонгосон бөгөөд хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон бөгөөд зардлын тооцоо шалгуур үзүүлэлтэд тохирох заалтыг[3] сонгон зардлын тооцоог хийв.

---

[2] *Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар* баталсан "**Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал**", 2.2.Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх үндсэн шалгуур үзүүлэлт дараах төрөлтэй байна:

2.2.1.зорилгод хүрэх байдал;
2.2.2.практикт хэрэгжих боломж;
2.2.3.ойлгомжтой байдал;
2.2.4.хүлээн зөвшөөрөгдөх байдал;
2.2.5.зардал;
2.2.6.харилцан уялдаа.

2.7."Зардал" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон улсын төсөвт ачаалал, хөнгөлөлтийг үүсгэх, төрийн байгууллагад хуулийн төслийг хэрэгжүүлэхэд үүсэх зардал, уг зардлын улмаас үүсэх үр дагавар зэргийг тооцон судална.

[3] *Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар* баталсан "**Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал**", Дөрөв. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх 4.1.Энэ үе шатанд шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлнэ.

| № | Шалгуур үзүүлэлт | Тохирох шалгах хэрэгсэл |
|---|---|---|
| 1 | Зорилгод хүрэх байдал | Зорилгод дүн шинжилгээ хийх |
| 2 | Практикт хэрэгжих боломж | Практикт турших |
| 3 | Ойлгомжтой байдал | Ойлгомжтой байдлыг шалгах |
| 4 | Хүлээн зөвшөөрөгдөх байдал | Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх |
| 5 | Зардал | Зардлын тооцоо хийх |
| 6. | Харилцан уялдаа | Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах |

Хуулийн төсөл нь 2 зүйлтэй бөгөөд энэхүү хуулийн төсөл Улсын төсөвт зардал үүсгэхгүй.

Учир нь Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг нь зөвхөн цагаатгуулах тухай өргөдөл, гомдлыг хүлээн авах хугацааг заасан байдаг бөгөөд хуулийн төсөл Улсын Их Хурлаар батлагдсан тохиолдолд Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын ажлын албаны тухайн жилийн үйл ажиллагааны төсөв болон орон тоонд ямар нэгэн байдлаар нөлөөлөхгүй одоогийн хүний нөөцөөр ажиллах боломжтой.

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

## УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙГ ЦАГААТГАХ ТЭДЭНД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/ 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг:**

"6.3. Цагаатгуулах тухай гомдлыг энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 2 жилийн дотор гаргаж болох бөгөөд энэ хугацаанаас хойш гаргасан гомдлыг хүлээж авахгүй."

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2023 оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь улсын төсөвт зардал үүсгэхгүй бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль болон Хүний эрхийн түгээмэл тунхаглалын зүйл заалтуудтай нийцэж буй учир дараах эерэг үр дагаврыг бий болгож байна. Үүнд:

- Цагаатгах ажил хуульд заасан хугацааны дагуу цаашид үргэлжлэн хэлмэгдсэн иргэдийг цагаатгах, нэр төрийг нь сэргээх эрх зүйн орчин бүрдэнэ.

- Хуулийн зүйл, заалтад шаардлагатай өөрчлөлтийг оруулснаар хууль хоорондын зөрчил арилна.

- Хуулийн үйлчлэх хугацааг сунгаж, хууль батлагдсанаар улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн гэх этгээдийг цагаатгуулах тухай өргөдөл, гомдлыг шийдвэрлэх болон улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн боловч хэрэг материал нь бүрэн шалгагдаагүй 451 хэрэг, өмнө шинэ нөхцөл байдлаар шалгаад улс төрийн хэрэгт холбогдсон болох нь нотлох баримтаар тогтоогдоогүй үндэслэлээр мөрдөн байцаалтыг зогсоосон 166 хэрэг, орон нутгийн архиваас

татан төвлөрүүлсэн 20 хэрэг, нийт 637 хэргийг бүрэн шалгаж цагаатгагдах, улс төрийн шалтгаанаар баривчлагдаж ЗХУ-д шийтгүүлсэн иргэдийн хэргийн материалыг судалж, тэднийг цагаатгах, цагаадсан иргэдийн материалыг татаж авах эрх зүйн орчин бүрдэж улс төрийн хэлмэгдүүлэлтийн улмаас нийгэмд учирсан хор хохирол, үүсэж бий болсон шалтгаан нөхцөл, хэлмэгдэгсдийг цагаатгах, нэр төрийг сэргээх, дурсгалыг мөнхжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах болно.

МОНГОЛ УЛСЫН ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИСС

## УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙГ ЦАГААТГАХ, ТЭДЭНД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг батлагдсан тохиолдолд практикт хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал"-ын дагуу хийв.

**Нэг.** Энэхүү хуулийн төсөл Улсын төсөвт нэмэлт зардал үүсгэхгүй.

**Хоёр.** Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн гэх боловч тодорхой шалтгааны улмаас шалгагдаагүй байгаа 637 хэргийн асуудлыг бүрэн шалгаж, цагаатгах эсэхийг эцэслэн шийдвэрлэхэд нэмэлт зардал шаардахгүй бөгөөд асуудал хариуцсан байгууллагын үндсэн төсвийн хүрээнд шийдвэрлээд явах боломжтой.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт оруулах өөрчлөлт нь Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын ажлын албаны орон тоонд ямар нэгэн байдлаар нөлөөлөхгүй одоогийн хүний нөөцөөр ажиллах боломжтой.

Хуулийн үйлчлэх хугацааг сунгаж, хууль батлагдсанаар улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн гэх этгээдийг цагаатгуулах тухай өргөдөл, гомдлыг шийдвэрлэх болон улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн боловч хэрэг материал нь бүрэн шалгагдаагүй 451 хэрэг, өмнө шинэ нөхцөл байдлаар шалгаад улс төрийн хэрэгт холбогдсон болох нь нотлох баримтаар тогтоогдоогүй үндэслэлээр мөрдөн байцаалтыг зогсоосон 166 хэрэг, орон нутгийн архиваас татан төвлөрүүлсэн 20 хэрэг, нийт 637 хэргийг бүрэн шалгаж цагаатгагдах, улс төрийн шалтгаанаар баривчлагдаж ЗХУ-д шийтгүүлсэн иргэдийн хэргийн материалыг судалж, тэднийг цагаатгах, цагаадсан иргэдийн материалыг татаж авах эрх зүйн орчин бүрдэж улс төрийн хэлмэгдүүлэлтийн улмаас нийгэмд учирсан хор хохирол, үүсэж бий болсон шалтгаан нөхцөл, хэлмэгдэгсдийг цагаатгах, нэр төрийг сэргээх, дурсгалыг мөнхжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан цагаан мөртэй, буянтай үйл хэрэг болох болно.

МОНГОЛ УЛСЫН ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИСС